



## ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: АШУҮИС

Хөтөлбөрийн нэр: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

Индекс: 102201

Шинжээчийн баг:

Ахлагч: Р.Чанцалдулам

Гишүүд: Б.Цогзолмаа

Ц.Хишигжаргал

2022 оны 11 сар 21-22

## Агуулга

I. Товчилсон үгийн тайлбар .....	4
II. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт .....	5
III. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга .....	6
IV. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт .....	7
шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт .....	7
шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа .....	9
шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл.....	<b>Error! Bookmark not defined.</b>
шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт.....	<b>Error! Bookmark not defined.</b>
шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа.....	<b>Error! Bookmark not defined.</b>
шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа .....	<b>Error! Bookmark not defined.</b>
шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
v. Дүгнэлт .....	25
VI. Нэгдсэн зөвлөмж .....	<b>Error! Bookmark not defined.</b>
VII. Ярилцлагад оролцогчдын нэрс .....	<b>Error! Bookmark not defined.</b>
VIII. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал.....	<b>Error! Bookmark not defined.</b>

## I. ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

БСШУСЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам
БМИҮЗ	Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний Зөвлөл
АШУҮИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
НЭМС	Нийгмийн эрүүл мэндийн сургууль
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
PEOs	Program Educational Objectives Хөтөлбөрийн боловсролын зорилтууд
PLOs	Program Learning Outcomes- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд
CLOs	Course Learning Outcomes Хичээлийн суралцахуйн үр дүнгүүд
ҮДСБ	Үр Дүнд Суурилсан Боловсрол
ЭЕШ	Элсэлтийн Ерөнхий Шалгалт
ЭША	Эрдэм Шинжилгээний Ажил
ШУТ сан	Шинжлэх Ухаан Технологийн сан
ЭШХ	Эрдэм Шинжилгээний Хурал
ЭШБх	Эрдэм Шинжилгээний Бага Хурал
ОЗ	Оюутны Зөвлөл

## II. ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮЙЛ ЯВЦ, ТӨЛӨВЛӨЛТ

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их сургуулийн Нийгмийн Эрүүл Мэндийн сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”	
Индекс	102201	
Шинжээчид	Р.Чанцалдулам – ХААИС-ийн ЭЗБС-ийн профессор, доктор Б.Цогзолмаа – Техник, технологийн дээд сургуулийн тэнхимийн эрхлэгч Ц.Хишигжаргал – Глобал куалити ХХК-ийн гүйцэтгэх захирал	
БМИҮЗ-ийн мэргэжилтэн	Б.Мядагмаа-БМИҮЗ-ийн магадлан итгэмжлэл хариуцсан ахлах шинжээч	
Төлөвлөгөө	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b> /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2022.11.21.	Хөтөлбөрийн нотлох баримттай сургууль дээр нь очиж танилцсан
	2022.11.22	Багш, оюутан, ажил олгогч, төгсөгчдийн төлөөлөлтэй танхим болон цахим уулзалтуудыг хийсэн
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ы өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур	

### III. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль нь анх 1956 онд эрүүл ахуйн тэнхим нэртэйгээр байгуулагдсан бөгөөд 2002 онд Нийгмийн эрүүл мэндийн сургууль нэртэй бүрэлдэхүүн сургууль болон өргөжиж 6 тэнхим, 6 профессор, 11 дэд профессор, 10 Ахлах багш, 19 багш бүхий нийт 53 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хөтөлбөр нь үр дүнд суурилсан хөтөлбөрийн үзэл баримтлалтай, нийт 126 кредит цагийг 4 жилийн хугацаанд судлах сургалтын төлөвлөгөөтэй ажилладаг.

Уг хөтөлбөр 2017-2022 он хүртэлх хугацаанд нийт 48 төгсөгчийг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэсэн. Хөтөлбөрийн агуулга, хөтөлбөрөөр төгсөгчийн мэдлэг, ур чадварт анхаарал хандуулж ажилладаг нь дараах үзүүлэлтүүдээс харагдаж байна.

- ✓ 2017 оноос хойш 5 жил сургалт явуулж ирсэн туршлагатай, багшлах бүрэлдэхүүний чадамж өндөр, мэргэжилтний хэрэгцээ, ажлын байрны эрэлт өндөр байгаа зэргээс харахад цаашид хөтөлбөр тогтвортой хэрэгжих бүрэн боломжтой байна.
- ✓ Хөтөлбөрөөр элссэн оюутнууд нь өөрийн сонирхлоор ирж суралцдаг нь хөтөлбөрийн давуу тал гэж харж болохоор байна.
- ✓ Хөтөлбөрийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, оролцогч талуудын санал хүсэлтийг тусгах, гадаадын ижил төстэй их, дээд сургуулиудын туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр туршлагатай, хичээн ажилладаг.
- ✓ Хичээл нэг бүрийн стандарт хөтөлбөрийг чанартай боловсруулсан. Судалж дууссаны дараа дүн гарахаас өмнө суралцагчдаас сэтгэл ханамжийн судалгааг онлайнаар авдаг болсон нь хөтөлбөрийг цаашид сайжруулах, удирдан зохион байгуулахад тус дөхөм болж байна.
- ✓ Сургуулийн удирдлага дотоод, гадаад хамтын ажиллагааг сайн хөгжүүлж, байгууллагатай хамтран лабораторийн туршилт, шинжилгээ хийж өгөх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэн, хөрөнгө оруулалт татаж чадсан сайн туршлага байна.

### ШАЛГУУР 1. ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

#### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

#### Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн эрэлт хэрэгцээг тодорхойлохдоо “Монгол улс дахь хөдөлмөрийн зах зээлийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хүний нөөцийн байдал” судалгааг хийж гүйцэтгэн эрэлт хэрэгцээ их байгааг олж тогтоосон байна.
- Хөтөлбөрийн сонирхогч болон оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааг авч дүгнэлт хийж ажилладаг.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй мэргэжилтний төгсөгчдийн 82.0 хувь нь 6 сарын дотор мэргэжлийн ажилд ордог нь эрэлт хэрэгцээ байгааг илэрхийлж байгаа бөгөөд энэ нь төгсөгчидтэй хийсэн уулзалтаар баталгаажсан.
- Гадаадын дараах их, дээд сургуулиудтай харьцуулан судалж хөтөлбөрийг сургалтын төлөвлөгөөний дүн шинжилгээ хийсэн. үүнд: University of Minnesota, Rutgers University, Murray state university, University of technology Mauritius.

#### Онцлог зүйл/Туршлага:

- Хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн чадамжийн шаардлагыг үндэслэн хөтөлбөрийг боловсруулсан.

#### Зөвлөмж:

- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний тандан судалгааг хийхдээ нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчин, улс төрийн болон хүмүүсийн эрэлт хэрэгцээ, орчин үеийн технологийн дэвшилтэд хөтөлбөр нь хэрхэн холбогдож байгааг судлах, судалгааны аргад STEEP, POEMS зэрэг аргыг ашиглах

### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

#### 1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

#### Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг тодорхойлохдоо АШУҮИС-ийн алсын хараа, эрхэм зорилго, НЭМС-ийн эрхэм зорилготой уялдуулан бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын дагуу боловсруулсан.
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлохдоо оролцогч талуудаар хэлэлцүүлсэн тухай холбогдох материал байхгүй.
- Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар, мэргэжлийн цогц чадамжийг тодорхойлохдоо 5 хүрээнд тодорхойлсон тухай өөрийн үнэлгээний тайланд дурдсан боловч хөтөлбөрийн үндсэн баримтад тусгагдаагүй байна.

- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлсэн талаар баримт материал байхгүй.

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн боловсролын зорилго (PEOs) -шинэчлэн сайжруулах

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн зорилго, зорилтод хүрэх стратеги төлөвлөлтийг хийж, түүнийг үнэлэх арга, хэмжих нэгжийг тодорхой болгон жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж ажиллах;

#### **Шаардлага:**

- Хөтөлбөрийн зорилго(PEOs), хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд(PLOs) хичээлийн хүрэх үр дүн (CLOs)-г боловсруулахдаа хамт олноор хэлэлцүүлдэг, хэлэлцүүлгийн үр дүнд гарсан шийдвэрийг тусгадаг тухай нотлох баримтыг бүрдүүлдэг байх;

### **Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

#### **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

##### **1. Хөтөлбөрийн баримт бичгийн бүрдэлт:**

- 2017 оны 03 сарын 09-ний өдрийн захирлын тушаалаар 4 жилийн 126 кредит судлахаар баталсан.
- Сургалтын хөтөлбөрийн агуулга, сургалтын төлөвлөгөөний багц цагийн бүрэлдэхүүн нь бакалаврын хөтөлбөрт тавигдах шаардлагыг (A/174) биелүүлсэн байна.
- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан бүх хичээлүүд нь батлагдсан хичээлийн стандарт хөтөлбөрүүдтэй. Хичээлийн стандарт хөтөлбөр нь хичээлийн зорилго, хүрэх үр дүн, лекц, дадлага, бие даалтын товч агуулга, хичээлийн удирдамж, оюутны гүйцэтгэлийг үнэлэх арга хэлбэрийг тодорхойлсон.
- Суралцагчид нь сургалтын нэгдсэн төлөвлөгөөгөөр нийт 126 кредит цаг судлах бөгөөд танилцах талбарын 2 удаагийн 8 кредит цагийн дадлага хийдэг байна.
- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын төлөвлөлттэй.
- Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааны тэмдэглэлтэй.

##### **2. Хөтөлбөрийг боловсруулсан байдал:**

Хөтөлбөрийн боловсруулахдаа дараах зүйлийг баримталсан:

- Дээд боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай Монгол улсын хууль
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах орон тооны ажилтан ажиллуулах норматив
- Гадаадын их, дээд сургуультай харьцуулан судалсан дүн шинжилгээ

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Анхаарах асуудал:**

- Хичээлийн суралцахуйн үр дүнг хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй уялдуулсан матриц боловсруулах

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгийг шинэчлэн сайжруулах
- Өөрчлөгдөн буй хөдөлмөрийн зах зээлийн эрэлт шаардлагад нийцүүлэн хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, төгсөгчийн цогц чадамжийг дахин шинэчлэн боловсруулах

### **1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## **Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа**

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

### **2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийн 27.3-т заасан чиг үүргийн дагуу ХАБЭА-н хөтөлбөрийн цогц чадамжид суурилсан мэдлэг, чадвар, хандлагын хүрээг шинэчлэн боловсруулсан.
- Суралцагч нь удирдлагын мэдээллийн системээр дамжуулан ерөнхий суурь, мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлүүдээс багц цаг нэмж сонгон судлах боломжтой.
- Хичээл бүрийн стандарт төлөвлөгөөг батлуулсан бөгөөд хичээлийн суралцахуйн үр дүнг тодорхойлсон,
- Сургалт, үйлдвэрлэлийн дадлага хийх байгууллагатай хамтын ажиллагааны гэрээтэй ажилладаг. Түүнчлэн суралцагчийн хүсэлтээр орон нутгийн байгууллагад ажлын байрны удирдагчийн удирдлагад өгсөн удирдамжийн дагуу хийх боломжийг олгодог.
- Хөтөлбөрийн зорилго, суралцахуйн үр дүнгийн дагуу хичээл хоорондын залгамж холбоог тодорхойлж, сургалтын технологийн залгамж холбоог хангахад чиглэн явуулдаг.
- Суралцагчийн цагийн ачаалал нь нэг улиралд 15 цаг цагаас илүүгүй байх гэсэн журмын заалтыг биелүүлдэг.
- GAP шинжилгээг анх нээх үед олон улсын ижил хөтөлбөрүүдийн сургалтын төлөвлөгөөтэй харьцуулсан хийсэн.

### **Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, хичээлийн үр дүн хоорондын хамаарлын матрицийг боловсруулах;
- Хөтөлбөрийн агуулгын шинэчлэлийг хийхдээ хөтөлбөрийн хүрэх үр дүн, төгсөгчийн загварт шинэчлэлт хийсний дараа сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт хийх;
- Анх батлагдсан цагаас эхлэн хөтөлбөрт шинэчлэлт хийгдээгүй.

#### **Зөвлөмж:**

- Сургалтын хөтөлбөрийн сайжруулалтыг үндсэн баримт бичигт тусгаж тасралтгүй сайжруулалтыг хийж хэвших;



### **Шаардлага:**

- Сургалтын хөтөлбөрийн агуулгад сайжруулалтыг хийх

### **2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургалтыг хөтлөн явуулахдаа оюутан төвтэй, тэдний оролцоог дэмжсэн үйлээр дамжуулан сургах идэвхтэй сургалтын арга зүйг ашигладаг.
- ХАБЭА хөтөлбөрийн эзэмших 5 цогц чадамж бүрд тохирсон сургалтын арга, хэлбэр, боловсруулсан байна.
- Идэвхтэй сургалтын арга зүйг хэрэгжүүлэх талаар нэгдсэн заавар, зөвлөмжтэй.
- Багш нарын сургалтын арга зүйд өгсөн суралцагчийн үнэлгээний үр дүнд дүн шинжилгээг сургалтын албанаас зохион байгуулдаг. Үнэлгээний тайланг багшийн аттестатчлалд хэрэглэдэг.
- Багш нар нь хичээлдээ сургалтын уламжлалт аргыг хэрэглэхээс гадна багаар ажиллах, харилцан ярилцах, тоглоомын арга, түүхт болон кэйс-д суурилсан орчин үеийн идэвхтэй сургалтын аргыг хослуулан хэрэглэдэг.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрт ашиглаж байгаа сургалтын арга зүйд дүн шинжилгээ хийх;
- Хичээлийн суралцахуйн үр дүнд өгсөн оюутны сэтгэл ханамжийн мэдээллийг багш бүрд хүргэж, дүгнэлт хийлгэдэг байх.

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн хувьд сурган заах арга, суралцахуйн үнэлгээ нь хоорондоо харилцан уялдаатай байх талд анхаарч хичээлийн түвшнээс хөтөлбөрийн түвшинд хүртэлх сургалтын болон үнэлгээний арга хэлбэрийн төлөвлөлт, хэрэгжүүлэлт, сайжруулалтыг тасралтгүй хийдэг тогтолцоог бүрдүүлэх.

### **2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- АШУҮИС-ийн захирлын 2021 оны А/19 тоот тушаалаар батлагдсан “Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах” журмаар төгсөгчийн эзэмшсэн цогц чадамжийн үнэлгээг хийдэг.
- АШУҮИС-ийн захирлын А/149 тоот тушаалаар батлагдсан суралцагчийг үнэлэх журмын дагуу суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлдэг.
- Б.Оюунгоо “Шалгалтын арга хэлбэрүүд” 2017 он, гарын авлагыг мөрдлөг болгодог.
- ХАБЭАХ төгсөлтийн шалгалтын сорилын эмхэтгэл 2021, 2022.
- Төгсөлтийн шалгалтын материалд тогтмол үнэлгээ хийдэг. Шалгалтын сорилуудыг жил бүр 20-30 хувьд нь шинэчлэлт хийдэг.
- Багшийн болон оюутны программтай.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Анхаарах асуудал:**

- Хичээлийн үнэлгээнд суралцахуйн үр дүнгийн гүйцэтгэл талаас нь дүн шинжилгээ хийж, хэрхэн сайжруулах талаар санал зөвлөмж гарган хэрэгжүүлж байгаа эсэх нь тодорхойгүй байна.

### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн хичээл нэг бүрийн суралцахуйн үр дүнг (CLOs) хичээлийн явцад болон төгсгөлд хэрхэн үнэлэх арга зүйн зөвлөмжийг боловсруулан суралцагчдад хүртээл болгох;
- Мэргэжлийн хөтөлбөрийн хувьд хичээлийн үнэлгээ, арга зүйг сайжруулах чиглэлээр зөвхөн мэргэжлийн тэнхимийн багш төдий биш бусад тэнхимээс тухайн хөтөлбөрт ордог багшийн хичээл, түүний үнэлгээ, арга зүйд анхаарч хөтөлбөр төвтэй ажиллах.

## **2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

#### **3.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- АШУҮИС-ийн НЭМС-ийн ХАБЭА-н бакалаврын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын байр, танхим, лаборатори, сургалтын хэрэглэгдэхүүн, багаж хэрэгсэл, чөлөөт цаг өнгөрөөх байгууламж, багшийн ажиллах орчин зэрэг нь стандарт шаардлагад нийцсэн байна.
- Сургалтын өрөөнүүдэд орчны эрүүл ахуйн хэмжилт хийж бүртгэл хөтөлж байна.
- Сургалтын орчинтой холбоотой оюутнуудаас авсан судалгаанаас харахад нэгдсэн дүгнэлтээр сэтгэл ханамж маш сайн гэж гарсан байна.
- Лабораторид хэмжилт хийж буй багаж, тоног төхөөрөмжүүдийн баталгаажуулалт хийгдсэн.
- Лабораторид орж ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгааны дагуу бүртгэл тогтмол хийгдэж байна.
- Хамтран ажиллаж буй байгууллагуудтай хийсэн гэрээний дагуу дадлага хийх, хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээн дээр хамтарч ажиллах зэрэг ажлууд хийгдэж байна.
- Оюутнууд дадлагын удирдамжийн дагуу дадлагаа үр дүнтэй хийж чадаж байна.
- Цахим контентуудын хамгаалалт сайн хийгдэж байна.

## **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалтын орчинд ашиглагдаж буй лаборатори нь итгэмжлэгдсэн байна.
- Итгэмжлэгдсэн лабораториар дамжуулан сурч байгаа мэргэжлийн дагуу туршилт, хяналт хийж байгаа нь ажлын байранд очиход бүрэн бэлтгэгдсэн мэргэжилтэн очих боломж бүрдсэн байна.
- Соёлын төв, спорт заал, Эко цогцолбор, мэргэжлийн клубууд зэрэгт оюутнуудын сэтгэл ханамж өндөр байна.

#### **Анхаарах асуудал:**

- Интернетийн орчинг сайжруулах
- Сургалтын орчинтой холбоотой судалгааг багш нараас авах
- Судалгааны дагуу хийхээр төлөвлөж буй ажлууд болон хийсэн ажлуудыг эргэж заавал мэдээлдэг байх
- Дадлага хийх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх

#### **Зөвлөмж:**

- Оюутны тоо нэмэгдэхээр анги танхимын хүрэлцээ багасах эрсдэлтэй тул энэ тал дээр төлөвлөж ажиллах

### **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн онцлогт тохирсон сургалтын хэрэглэгдэхүүн хангалттай байна.
- 14 төрлийн хэмжилт хийх тоног төхөөрөмжүүд, компьютер, хэвлэмэл үзүүлэн, хувийн хамгаалах хэрэгсэл болон сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглаж байна.
- Сургалтын цахим систем ашиглаж 21 суурь хичээл, 16 мэргэжлийн хичээл, 26 мэргэшүүлэх хичээлийн лекц цахим хэлбэрээр байршсан.
- Багшийн хөгжлийн төв үйл ажиллагаа сайн байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Энэхүү хөтөлбөр нь АШУҮИС дээр хэрэгжиж байгаа нь онцлог байна.

#### **Анхаарах асуудал:**

- Сургалтын хэрэглэгдэхүүний нөөцийн судалгаа хийх
- Цахим контентуудыг сайжруулах давтамжийг тодорхойлж тасралтгүй сайжруулалт хийж байх

#### **Зөвлөмж:**

- Салбарын хөгжлөөс байнга суралцаж шинэлэг мэдээллүүд, сургалтын хэрэглэгдэхүүн, сургалт судалгааны программ хангамжийг ашиглах, хөгжүүлэх боломжуудыг эрэлхийлэх

### **3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг болохуйц номын сан, номын фондтой байна.
- Номын сангуудыг ангилсан байдал нь ашиглалтыг сайжруулсан байна.

- Сургалтын үйл ажиллагааны чухал хэсэг нь сурах бичиг, гарын авлага байдаг ба эдгээрийг бий болгох, тасралтгүй хөгжүүлэх тал дээр анхаарч ажиллаж байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Ном сэргээх үйл ажиллагаа онцлог байна.

#### **Анхаарах асуудал:**

- Оюутнуудаас гарсан саналын дагуу номын сангууд хуваарийн дагуу ажиллаж байгаа хэдий ч эдгээр цагуудаас бусад цагт ашиглах номын санг бий болгох тал дээр анхаарах;

#### **Зөвлөмж:**

- Сургалтад ашиглаж буй ном, гарын авлагын хэвлэгдсэн он буюу сүүлийн хувилбар мөн эсэхэд анхаарах;
- ХЭМАБ-ын хөтөлбөр нь Монгол улсын хэмжээнд шинэ байгаа тул ном сурах бичгийн тал дээр сайжруулах шаардлага гарсаар байгаа, иймээс сургалтын хөтөлбөр, агуулгатай уялдуулж ном сурах бичгийн сан бий болгох тал дээр анхаарах;

**3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан.**

## **Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

### **4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Их сургуулийн хэмжээнд хөтөлбөрийн ерөнхий хороо, бүрэлдэхүүний сургуулийн хувьд дэд хороог байгуулан үйл ажиллагаа нь тогтмол ажиллаж байгаа нь хурлын тэмдэглэлээс харагдаж байна.
- НЭМС-ийн хөтөлбөрийн дэд хороо нь 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр хэрэгжүүлж буй хөтөлбөрийг сайжруулах чиглэлээр төлөвлөгөө гарган ажилладаг.
- Сургалтын удирдлага мэдээллийн системийг 2014 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Уг систем нь сургалтын бүхий л үйл ажиллагааг зохицуулах, хяналт шинжилгээ хийх, цахим элсэлт болон сургалт явуулах платформ зэрэг нь хэвийн ажиллаж байна.
- Хөтөлбөрийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэхдээ сургуулийн цахим хуудсаар дамжуулан түгээдэг түүнчлэн нүүр хуудсаар дамжуулан мэдээллийг хүргэдэг.
- 2018 онд хөтөлбөрийг сайжруулах ажлын төлөвлөгөөг гаргаж ажилласан байна. Харин ажлын төлөвлөлтийн биелэлтэд хяналт, дүн шинжилгээ хийгдээгүй.
- Суралцагчдын санал гомдлыг сургуулийн холбогдох дүрэм, журмын дагуу шийдвэрлэдэг.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

## **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн хувьд тогтвортой байдлын шинжилгээ болон стратегийн төлөвлөлтийг гаргаж ажиллах

## **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийг сайжруулах, удирдах чиглэлд хөтөлбөрийн оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлж хамтын ажиллагааг бэхжүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлэх;
- Хөтөлбөрийг сайжруулах талаар хөтөлбөрийн хороод төлөвлөгөө гаргаж ажиллах.

### **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

## **Илрэл нотолгоо:**

- Тус сургууль нь хөтөлбөрийн сургалт, үйлдвэрлэлийн дадлага хийлгэх, сургалт, судалгааны чиглэлээр дотоодын 12, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай тус тус хамтран ажилладаг.
- Өөрийн лабораторийн үйл ажиллагаагаар дамжуулан багш, оюутнуудтай хамтран захиалгат байгууллагуудын ажлын байрны аюулгүй байдлын шинжилгээг хийж, зөвлөмж өгдөг.
- АШУҮИС-ийн төгсөгчдийн холбоотой бөгөөд “Алтангагнуур” үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулдаг.

## **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

## **Анхаарах асуудал:**

- Гадаад дотоодын байгууллагатай ажиллах цар хүрээгээ нэмэгдүүлэх;

## **Зөвлөмж:**

- Мэргэжлийн төгсөгчдийн холбоог байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах.
- Нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, нийгэмд байгаа бодит асуудлуудыг шийдэхэд багш, оюутнуудыг татан оролцуулах талд анхаарах.

### **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

## **Илрэл нотолгоо:**

- АШУҮИС -ийн нийт орлогыг 1) сургалтын төлбөр, 2) төсөл хөтөлбөр, 3) бусад төв болон лабораторийн орлого гэсэн 3 хэсгээс бүрдүүлдэг ба сургалтын төлбөрийн 88 хувийг багш, ажилтны цалинд, 12 хувийг хичээл практикийн зардалд зарцуулдаг байна.
- НЭМС нь 2014 оноос эхлэн төсөв санхүүгийн хувьд бие дааж ирсэн. Хөтөлбөрийн төсөв нь АШУҮИС-ийн нэгдсэн төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч НЭМС-ийн төсвөөс санхүүждэг болно.

- Тус хөтөлбөрийн хувьд сүүлийн 4 жилийн байдлаар багц цагийн үнэлгээ нь 99100-117610 төгрөгийн хооронд байсан байна. Сургалтын төлбөр нь сүүлийн 5 жилийн дунджаар 3,519,616 төгрөг байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд зориулсан дотоод, гадаадын төсөл, хөтөлбөрийн эх үүсвэрээс санхүүжүүлэн анги танхим, лабораторийг тохижуулж суралцах таатай орчинг бүрдүүлж байгаа нь сайшаалтай.
- Лаборатороос орлого олж сургалтын материаллаг баазыг нэмэгдүүлдэг.

#### **Зөвлөмж:**

- Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөх үйлчилгээг хийх;

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахад чиглэсэн маркетингийн идэвхжүүлэлтийг дараах байдлаар хэрэгжүүлдэг. Тухайлбал:
- Хичээлийн шинэ жилийн эхэнд НЭМС-ийн ОЭМТ-ийн төгсөгчид болон оюутны төлөөлөл оролцсон мэргэжил сурталчлах 4 минут, 46 секундын шторк бэлтгэж сургуулийн вэбсайт /mnuns.edu.mn/, БШУЯ-ны портал сайт [www.meds.gov.mn/](http://www.meds.gov.mn/), мөн [https://www.youtube.com/watch?v=hh\\_r32m08Ik/](https://www.youtube.com/watch?v=hh_r32m08Ik/) нийгмийн сүлжээнд байршуулан олон нийтэд сурталчилж байна.
- АШУҮИС, НЭМС-ийн пейж хуудсаар мэргэжлийн сурталчилгаа, ажлын байрны зарыг тогтмол тавьж байна
- “Хөдөлмөрийн эрүүл ахуйчдын үндэсний холбоо” нэртэй цахим хуудсаар дамжуулан 14 хоног тутам мэргэжлийн чиглэлийн хүмүүс оролцсон сургалтыг тогтмол явуулж байгаа ба холбооны гишүүддээ мэргэжлээ сурталчлах, сургалт зохион байгуулж, байна.
- ЕБС-ийн болон АШУҮИС-ийн Лицей сургуулийн 10-12-р ангийн сурагчид, оюутан, төгсөгчдөд зориулсан Хөдөлмөрийн эрүүл ахуйн чиг баримжаа олгох, мэдээлэл солилцох уулзалт, сургалтуудыг цахим, хуралдаан, семинарын хэлбэрээр зохион байгуулж байна. /Ж-нь: Нэн түрүүнд ХАБ-2022” хуралдааныг 11 дэх жилдээ 2022.09.14-30-нд зохион байгуулсан/

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- ХАБЭА-н тулгамдсан асуудлыг тодорхойлох, төгсөгчидтэй холбоотой байх мэргэжлийн чиглэлээр хамтын ажиллагааг дэмжих зорилготой АШУҮИС-ийн удирдлагууд, НЭМС-ийн ОЭМ-ийн тэнхимийн багш, төгсөгч, оюутнуудаас бүрдсэн 3638 гишүүнчлэлтэй “Хөдөлмөрийн эрүүл ахуйчдын үндэсний холбоо” байгуулан ажиллаж байгаа нь хөтөлбөрөө сурталчлах маркетингийн идэвхжүүлэлтийн томоохон ажил болсон байна.

#### **Анхаарах асуудал:**

- Мэргэжлийн холбоодоор дамжуулан хөтөлбөрөө сурталчлах, хөтөлбөрт сайжруулалт хийх талаар санал, зөвлөмжийг тусгаж байхад анхаарах

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөр, мэргэжлийн ач холбогдол, давуу талыг олон нийтэд сурталчлан таниулах талаар мэргэжлийн багш, тэнхим, төгсөгчдийн оролцоог нэмэгдүүлэх талаар хийсэн үйл ажиллагааг нэгтгэн дүгнэдэг, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ төлөвлөж байх
- Хөтөлбөрийн маркетингийн бодлогыг хэрэгжүүлэхдээ мэдээллийн технологийн хөгжлийн ололтыг ашиглах бодлого баримтлах.

#### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь олон нийт, элсэгчид, суралцагчид, төгсөгч, ажил олгогч нарт хөтөлбөрийн талаарх мэдээллийг олон сувгаар ил тод байдлаар мэдээлэх асуудлыг ОЭМ-ийн тэнхим гардан зохион байгуулж байна.
- Мөн дээрх оролцогч талуудаас сэтгэл ханамжийн судалгааг жил бүр асуумжаар авч, саналыг хөтөлбөрт тусган ажилладаг.
- Хөтөлбөрийн хүрээнд судлах хичээлийн танилцуулга, сургалтын төлөвлөгөө, үнэлгээний аргачлалыг багш, оюутны “xcloud” программд оруулж ил тод байдлыг хангаж байна

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн нээлттэй байдлын талаар сонин сэтгүүл ном товхимол, гарын авлагаар түгээн дэлгэрүүлэхэд анхаарч ажиллах

#### **Зөвлөмж:**

- Маркетингийн идэвжүүлэлтийн арга хэмжээний ажлын төлөвлөгөө, тайлан, түүнээс гарсан үр дүнг нэгтгэн цаашдын үйл ажиллагаандаа тусгаж байх
- Мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж элсэлтийг нэмэгдүүлэх

#### **4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

#### **5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- АШУҮИС-ийн Оюутан элсүүлэх журамтай
- АШУҮИС-ийн [www.mnums.edu.mn](http://www.mnums.edu.mn) вэб сайтын ажиллагаа хэвийн.
- Тухайн жилийн элсэлтийн комиссын ажлын тайлан
- Элсэлтийн бүртгэл хийх цахим хаяг <http://burtgel.mnums.edu.mn> хаягтай
- Элсэлтийн бодлого, дүрэм журам АШУҮИС-ийн “Оюутан элсүүлэх тухай” журмаар зохицуулагддаг.



- Жил бүрийн элсэлтийн үйл ажиллагааг зохицуулах элсэлтийн комисс томилогдон шинэ элсэгчдийг бүртгэн холбогдох хөтөлбөрөөр суралцуулахаар элсүүлж байна.
- Оюутан элсүүлэх журам нь сургуулийн [www.mnums.edu.mn](http://www.mnums.edu.mn) вэб сайтад нээлттэй байдаг.

### **Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- ХАБЭА-н ангид элсэгчдийг зөвхөн хими, физикийн хичээлээр элсэлтийн оноогоор шалгаруулж байсан бол 2022 оны хичээлийн жилээс хими, физик, математик, нийгмийн тухай мэдлэг хичээлүүдийн өндөр онооны шалгуураар авч байгаа нь элсэгчдийн тухайн мэргэжлийг сонгох боломжийг бий болгосон байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй оюутанд хүрч ажиллах, шинэ элсэгчдэд мэргэжлийн чиг баримжаа олгох 7 хоногийн “Удиртгал” хичээлийг зохион байгуулж элсэгчдийг шаардлагатай бүх мэдээллээр хангаж байгаа нь давуу талтай байна.

#### **Анхаарах асуудал:**

- Элсэгч бүрдүүлэх талаар хийсэн ажлуудын үр дүн хангалтгүй, тухайн хөтөлбөрөөр элсэгчид бууралттай байгаад дүгнэлт хийж ажиллах

#### **Зөвлөмж:**

- Ажил олгогчийн болон нийгмийн эрэлт хэрэгцээний захиалгад үндэслэн элсэлтээ бүрдүүлэх талаар элсэлтийн бодлогыг чиглүүлж ажиллах

#### **Шаардлага:**

- Элсэлтийг нэмэгдүүлэхэд маркетингийн идэвхжүүлэлт, хөтөлбөрийн ил тод байдлыг нэмэгдүүлж, хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангах

### **5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Суралцагчдад чиглэсэн зөвлөн туслах үйлчилгээг сургуулийн “Оюутны хөгжил удирдлагын газар” нэгдсэн удирдлагаар хангадаг ба “Оюутны хөгжил” хөтөлбөр хэрэгжиж байна.
- “Оюутны хөгжил” хөтөлбөр хэрэгжүүлж байгаа нь оюутны тасралгүй хөгжих, суралцах үйл явц, эрх ашгийг хамгаалах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зэрэг давуу талтай байна.
- Нийгэмд чиглэсэн аянууд зохиогдож түүнд ХАБЭА-н оюутнууд төлөөлөн оролцож байна. /“Хөдөлмөрч оюутан”, “Үлгэрлэгч оюутан” хөтөлбөрт ХАБЭА-н 10 оюутан, “Улсын Дархан –Хил” аялалд 2 оюутан, “Дусал цус-Дүүрэн амьдрал” аянд 8 оюутан нийт давхардсан тоогоор 20 оюутан оролцсон/
- Сургууль арга зүйчтэй ба оюутанд зөвлөн туслах үйл ажиллагаа явуулдаг.
- Сургууль, тэнхимээс зөвлөн туслах арга зүйн зөвлөгөөг судалгааны арга зүй, хөдөлмөр, орчны эрүүл ахуйн хэмжилтийн арга зүй, үнэлгээ, ЭШ-ний өгүүлэл бичих гэх мэт 7 чиглэлээр үзүүлж байгаагаас судлаач оюутны тоо өсч оюутны эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавин оролцож байна. Тухайлбал:НЭМС-ийн хэмжээнд зохион байгуулсан ОЭШ-ний хурлын шилдэг 15 илтгэлийн 5-ыг ОЭМТ-ийн оюутнууд тавьсан байна.



- ХАБЭА -н 4-р дамжааны Б.Заяасайхан тэргүүтэй 3 оюутны бэлтгэсэн “ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдын хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын мэргэжилтэн мэргэжлийн талаар мэдлэг, хандлагын судалгаа” сэдэвт илтгэл Шилдэг аман илтгэлээр шалгарсан нь арга зүйн ажлын үр дүн гэж үзэж байна.
- НЭМС-ийн ОЭМ-ийн тэнхимээс ХАБЭА-н ангийн оюутнуудыг төсөл, судалгааны ажилд дэмжин оролцуулж байна. Тухайбал: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, Эрдэнэс таван толгой ХХК-иас хамтран зохион байгуулсан “Эрүүл уушигны төлөө хамтдаа” аянд Багш Г.Жаргалсайханаар удирдуулан ХАБЭА-н ангийн 3,4-р курсын 6 оюутан эрүүл ахуйн хэмжилт үнэлгээг хийсэн байна.
- Мөн Таван толгой-Гашуун сухайт чиглэлийн нүүрс тээвэрлэгчдийн ажлын байранд цулцанд нэвтэрдэг тоос, 16 төрлийн хүнд металл, тоосны өртөлтийг тодорхойлох хэмжилт, үнэлгээний ажилд оролцсон ба үүнд 111 ААНБ-ын 600 гаруй жолооч, тээвэрчид хамрагдсан зэрэг төсөл хөтөлбөрүүдэд оролцуулан ажилласан байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Оюутны хөгжил хөтөлбөрийн хүрээнд оюутныг дэмжих “Үлгэрлэгч оюутан”, “Хөдөлмөрч оюутан”, “Эх оронч оюутан”, “Эрүүл-авьяаслаг оюутан” зэрэг 4 дэд хөтөлбөрөөр оюутны идэвх санаачилгыг дэмжин хөгжүүлж байна.
- Дээрх хөтөлбөрүүдэд ХАБЭА-н хөтөлбөрөөр суралцаж байгаа давхардсан тоогоор 22 оюутан идэвхтэй хамрагдсан байна.
- Тэнхимийн зүгээс оюутныг эрдэм шинжилгээ судалгааны ажлыг дэмжих, удирдах, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлдэг ба түүний үр дүнд оюутнууд судалгааны ажил хийж мэргэжлийн үнэлгээ, дүгнэлт гаргахад хамтран ажиллаж байгаа нь оюутны сурах үйл ажиллагааг дэмжсэн давуу тал гэж үзлээ.

#### **Анхаарах асуудал:**

- Төгсөгчидтэй хийсэн уулзалтаас ХАБ-ын чиглэлээр илүү мэдлэг шаардлагатай байгааг дурьдсан тул оюутнуудыг судалгааны болон төсөлт ажилд оролцуулахдаа ХАБ-ын талаарх мэдлэгийг олгоход анхаарч ажиллах

#### **Зөвлөмж:**

- Зохион байгуулсан ажил, түүний үр дүнг нэгтгэн дүгнэх, тоо баримт, нотолгоог хийсэн ажлын үр дүнтэй холбох, харьцуулсан дүгнэлт гаргаж байх

### **5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Суралцагчдыг олон нийтийн арга хэмжээ, судалгаа, шинжилгээний ажилд оролцсон оролцоог дэмжсэн урамшууллын тогтолцоотой.
- Сургуулийн хэмжээнд олон нийтэд болон суралцагчдын дунд зохион байгуулдаг төрөл бүрийн аян, урлаг спортын арга хэмжээ, сайн дурын ажил, клубууд ажилладаг ба энэхүү арга хэмжээнүүдэд ХАБЭА-н хөтөлбөрийн оюутнууд идэвхтэй хамрагдаж байна.
- Спортын уралдаан тэмцээнд амжилт гаргасан 5 оюутанг НЭМС-иас мөнгөн шагналаар урамшуулсан байна.

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны хөгжил хөтөлбөрийн “Хөдөлмөрч оюутан” дэд хөтөлбөрөөр оюутнууд бүтээл хийж орлого олох хөдөлгөөнийг зохион байгуулсан нь оюутны бүтээлч сэтгэлгээг дэмжсэн ажил болсон байна.

### Анхаарах асуудал:

- Оюутны санаачилгыг дэмжиж, өөрөө хөгжих боломжийг бий болгох.

### Зөвлөмж:

- Цаашид оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн дагуу ХАБЭА-н оюутнуудын сайн дурын хөдөлмөр эрхлэлт, бүтээлч байдлыг дэмжсэн бодлого хэрэгжүүлэх

#### 5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

### Илрэл нотолгоо:

- Оюутны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах АШУҮИС-ийн дүрэм журамтай.
- Тайланд дурьдсан шилжилт хөдөлгөөний сүүлийн 3 жилийн тоон мэдээний хүснэгтээс харвал жилийн чөлөөнд 2, шилжсэн 2 нийт 4 суралцагч хөдөлгөөнд орсон байна.
- Шилжилт хөдөлгөөнийг нэг жилийн хугацаатай сургалтын чөлөө олгох, суралцах эрхийг түтгэлзүүлэх, суралцах эрхийг нээх, гадаад, дотоодын их дээд сургуулиас шилжин суралцах, сургуулиас чөлөөлөх зэрэг бодлогын баримт бичгийн хүрээнд зохицуулдаг.
- Тайлангийн хугацаанд 4 оюутан шилжилт хөдөлгөөнд орсон нь нийт суралцагчийн 8,8%-ийг эзлэж байгаа нь оюутны шилжилт хөдөлгөөн тогтвортой байна.

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Анхаарах асуудал:

- Элссэн суралцагчдын шилжилтээр хөтөлбөрөөс гарч байгаад үнэлгээ дүгнэлт хийж байх

### Зөвлөмж:

- Элсэлтийг нэмэгдүүлэхэд оюутан суралцагчдын оролцоог нэмэгдүүлэх, элсэлт бүрдүүлэхэд оролцсон оюутнуудыг урамшуулах гэх мэт шилжилт, хөдөлгөөнтэй холбоотой асуудлыг жил бүр авч хэрэгжүүлж байх

#### 5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

### Илрэл нотолгоо:

- ХАБЭА-н сургалтын хөтөлбөрөөр төгсөгчид АШУҮИС-ийн “Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 5-р заалтын дагуу явагдаж байна.
- Төгсөлтийн үнэлгээг “Төгсөгчийн мэдлэгийг үнэлэх шалгалт”, “Төгсөгчийн ур чадварыг үнэлэх шалгалт” гэсэн үе шатаар зохион байгуулж байна.

- Төгсөлтийн баримт бичиг болох Диплом нь ДБС-ын дипломын бичилтэнд тавигдах шаардлагын дагуу нүүр, хавсралт, 4 жилийн хугацаанд судалсан ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээл, сонгон судлах хичээл, дадлага гэсэн 126 кр бүхий 53 хичээлийн нэрс, дүнгээс бүрдсэн нь БШУС-ын А/174 тушаалын заалтад нийцэж байна.
- Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдал мэргэжлээр тайлангийн хугацаанд 2 удаагийн төгсөлт хийж, нийт 48 оюутан төгссөн.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Төгсөлтийн ур чадварын үнэлгээг өртөөлчилсэн байдлаар дуураймал орчинд багаж тоног төхөөрөмж ашиглан зохион байгуулж байгаа нь төгсөгч хөрвөн ажиллах ур чадварыг олгож байгаа давуу тал байна.

#### **Анхаарах асуудал:**

- Төгсөгчдийн ажлын байранд гараад дутагдаж байгаа ур чадварыг судлаж, хөтөлбөртөө тусгаж байх

#### **Зөвлөмж:**

- Төгсөлтийн дараах мөшгих судалгааг хийж байх

### **5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа**

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

##### **6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого**

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- АШУҮИС нь Багш нарыг сонгон шалгаруулах, албан тушаалын зэрэглэл тогтоох, хөгжүүлэх, урамшуулах эрх зүйн зохицуулалтуудыг боловсруулан мөрдөж ажилладаг.
- Багш хөгжүүлэх цахим сургалтын төв байгуулсан: “Багшийн хөгжлийн хөтөлбөр”-тэй.
- Багш хөгжлийн хөтөлбөрөөр “Багшийн алтан дүрэм”, “Багшийн үйл ажиллагаа гүйцэтгэлийг тооцох журам” зэргийг мөрдөн ажиллаж байна.
- Тухайн хөтөлбөрийн хүний нөөцийн судалгаагаар 28 багшийн 21%-нь доктор, 79 % нь магистр зэрэгтэй багш нартай байгаа нь сургалтыг явуулах ур чадвартай багш нарыг бүрдүүлсэн байна.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын албан тушаалын зэрэглэлийг авч үзвэл профессор-2, дэд профессор-2, ахлах багш-5, багш-11, дадлагажигч багш-8 ажиллаж байна.
- Сүүлийн 5 жилийн хугацаанд багш нараас 3 багш албан тушаалын зэрэглэл ахисан, 2 багш төрийн одон медалиар, 21 багш салбарын болон бусад шагналаар шагнагдсан нь багшийг урамшуулах бодлого хэрэгжиж байна.

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- Залуу багш нарыг дадлагажуулан хүний нөөцөө бүрдүүлэх талаар ажиллаж байгаа нь хөтөлбөрийн хөгжих боломжийг бий болгох сайн талтай

### Анхаарах асуудал:

- Дадлагажигч багш нар нийт багшийн 28%-ийг эзлэж байгаа нь их сургуулийн түвшинд хэрхэн нийцэж байгаад анхаарах

### Зөвлөмж:

- Багш нарыг албан тушаалын зэрэглэл ахихад анхаарч ажиллах, ялангуяа дадлагажигч багш нарын зэргийг ахиулах

## 6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

### Илрэл нотолгоо:

- АШУҮИС-иас багш нарын сургалт заах арга зүйг сайжруулах зорилгоор 6 багц цагтай "Анагаахын боловсрол судлал" сургалтыг хэрэгжүүлдэг ба тус сургалтанд ажилд шинээр орсон болон дадлагажигч багш нарыг хамруулан сургаж, багшлах эрх олгож байна.
- АШУҮИС-ийн 2015-2024 онд хөгжүүлэх стратегийн төлөвлөгөөнд "Эрдэм шинжилгээний хувьд манлайлагч дэлхийн шилдэг 1000 их сургуулийн нэг болох" зорилгыг хэрэгжүүлэхэд НЭМС-нь захиалгат төсөл, судалгаа, гэрээт ажил, хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүйн хөгжүүлэлт зэрэг арга хэмжээний хүрээнд сүүлийн 5 жилд ОЭМТ, ХАБЭА-н хөтөлбөрийн багш нар дотоодын санхүүжилттэй 28, гадаадын санхүүжилттэй 8, нийт 36 төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн байна.

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- "Багшийн алтан дүрэм"-ээр багшийн сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн болон хувь хүний мэдлэг, чадвар, хандлагыг тасралтгүй хөгжүүлж, туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилтыг тавьж Багшийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа нь багш өөрөө хөгжих, хөгжих хэрэгцээгээ тодорхойлоход ач холбогдолтой байна.

### Анхаарах асуудал:

- Дотоод, гадаадын олон сургалтууд явагдаж багш нар хамрагдсан боловч багшлахуйн болон судалгааны ямар ур чадвар, арга зүйгээ дээшлүүлсэн талаар судалгаатай байх

### Зөвлөмж:

- Багшийн заах арга, ур чадвар, хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүйг хөгжүүлэхэд багшийн хөгжлийг чиглүүлэх

## 6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

## **Илрэл нотолгоо:**

- АШУҮИС-ийн 2015-2024 онд хөгжүүлэх стратегийн төлөвлөгөөнд “Эрдэм шинжилгээний хувьд манлайлагч дэлхийн шилдэг 1000 их сургуулийн нэг болох” зорилгыг хэрэгжүүлэхэд НЭМС нь захиалгат төсөл, судалгаа, гэрээт ажил, хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүйн хөгжүүлэлт зэрэг арга хэмжээний хүрээнд сүүлийн 5 жилд ОЭМТ, ХАБЭА-н хөтөлбөрийн багш нар дотоодын санхүүжилттэй 28, гадаадын санхүүжилттэй 8, нийт 36 төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн байна.
- ЭШ-ний өгүүлэл, илтгэл нийт 800-аадыг хэвлүүлсэн ба үүнээс гадаадад 179, дотоодод 606 хэвлүүлсэн нь хангалттай байна.
- Сургуулийн бодлогын хүрээнд багшийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийхийг эрчимжүүлэх, дэмжих зорилгоор /IF/ индекс бүхий олон улсын сэтгүүлд 1-р зохиогчоор судалгааны ажил хэвлүүлсэн багш, ажилтанд урамшуулал олгож эхлээд байгаа нь багш нарын эрдэм судлалын ажлыг дэмжсэн ажил болсон байна. Тухайлбал: 2020 онд 1 багш 1-р зохиогчоор 1500,0 мян.төг-ийн, 2021 онд 3 багш хамтарсан бүтээлээр 900,0 мян.төг-ийн урамшуулал авсан байна.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулах төсвийг сургуулийн төсөвт суулгах, Бүрэлдэхүүн сургуулийн хэрэгжүүлж буй төслийн санхүүжилтийн 5-15%-ийг ЭШ-ний зардлын хуримтлал үүсгэх бодлого баримтлан ажиллаж байна.
- НЭМС-нь өөрийн санхүүжилтээс 2017-2022 оны хооронд нийт 49,5 сая. төг буюу жилд дундажаар 9.9 сая.төг-ийг эрдэм шинжилгээнд зарцуулсан байна.
- Мөн багш нарыг гадаадын их сургуулиудад сургалтанд хамруулж, дэмжлэг үзүүлж байна. Багш Г.Жаргалсайхан /2017/ Эрхүүгийн АУС-ийн Эрүүл ахуйн факультетэд, багш Э.Ундармаа Канадын Саймон Фрейзерийн их сургуульд, Ц.Оюу Солонгосын Сеүлийн Их сургуульд докторантурт суралцаж байна.
- НЭМС- нь АНУ-ын Duke их сургууль, ХӨСҮТ хамтран АНУ-ын Эрүүл мэндийн институтын /NIH/ санхүүжилттэй орчны эрүүл мэндийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх саналыг хүргүүлж дэмжигдсэн ба төслийн хүрээнд ОЭМТ-ийн залуу багш нар төслийн судлаач, зохицуулагчаар ажиллахын зэрэгцээ 15 сарын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах, 3 сар Duke их сургуулийн тэтгэлэгээр суралцах боломж бүрдэх зэрэг гадаад дотоодын төсөл хөтөлбөрт хэрэгжүүлэхэд санаачилгатай ажиллаж байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- НЭМС-ийн ОЭМТ-ээс 2018 онд 69,0 сая,төг, 2020 онд 42,0 сая.төг, 2021 онд 10,8 сая.төг-ийн санхүүжилттэй төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн нь эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх боломжийг бүрдүүлсэн байна.

#### **Анхаарах асуудал:**

- ХАБЭА-н хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нар эрдэм судлалын ажил хангалттай хийж байгаа боловч үйлдвэрлэлд нэвтрүүлэх, шинэ инноваци, патентжуулах зэрэг бодит ажил хангалтгүй байгаад анхаарах

#### **Зөвлөмж:**

- Төсөлт ажилд багш нарыг жигд оролцуулах, төсөл хөтөлбөрөөс орох санхүүжилтээс багш нарыг чадвахжуулах, урамшуулах боломжийг бий болгох

## **6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

#### **Илрэл нотолгоо:**

- АШУҮИС-ийн захирлын “Багшийн үйл ажиллагааг зохицуулах журам”, “Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журам”-ын дагуу багшийн өөрийн, удирдлагын, оюутны гэсэн 3 үнэлгээгээр үнэлэгдэх дүрэм журамтай байна.
- Сүүлийн 5 жилд хөтөлбөрийн багш дунджаар 80%-тай үнэлэгдсэн байна.
- Багш бүр өөрийн хавтсыг цахим болон цаасан хэлбэрээр бүрдүүлдэг. Багшийн хавтсанд үндсэн багшийн мэдээлэл, сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа, шагнал урамшуулал зэргийг багтаасан нь багшийн үйл ажиллагааг нэгтгэн харах боломжтой.
- Багш бүр нээлттэй хичээл заах үүрэгтэй. Нээлттэй хичээл зааж байгаа багшийн хичээлд урьдчилсан зарын дагуу багш ажилтнууд хамрагдан үнэлгээ хийх боломжтой.
- ОЭМТ-ийн багш нар 15 удаагийн нээлттэй хичээл зааж, бусад багш нартай арга зүйгээ хуваалцсан байна.
- Суралцагч нараас хичээлийн талаарх үнэлгээг цахим, цаасан хэлбэрээр авдаг.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Нээлттэй хичээлийг цахим хэлбэрээр нийт багшийн дунд нээлттэй явуулж арга зүйгээ солилцож байгаа давуу талтай байна.

#### **Анхаарах асуудал:**

- Нээлттэй хичээлийн үр дүнг тэнхимд хэлэлцэж, арга зүйгээ сайжруулах тэмдэглэл хөтлөн, нотолгоогоо бүрдүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд анхаарах

#### **Зөвлөмж:**

- Багшийн үнэлгээний нэгдсэн дүнгээс хөтөлбөрийн хэмжээнд сайжруулах болон түгээн дэлгэрүүлэх сайн арга зүй, сургалт, судалгааны ажлыг нэгтгэн хөтөлбөртөө тусган шинэчлэл хийж байх.

#### **6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

##### **7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн чанарыг хангах зорилгоор Хяналт шинжилгээ үнэлгээний газар ажиллаж байна. ХШҮГ нь жилийн төлөвлөгөө гаргаж төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.
- Чанарын үнэлгээ, баталгаажилттай холбоотой 7 журам батлагдаж мөрдөгдөж байна.

- Эрдмийн зөвлөлийн хажууд хөтөлбөрийн хороо, дэд хороод ажиллаж хөтөлбөрийн сайжруулалт, суралцахуйн орчин, багшлахуй ба суралцахуйн үнэлгээ, элсэлт ба төгсөлт гэсэн үе шат бүрийг хамран ажиллаж байна.
- Сургалтууд цахимд шилжсэнтэй холбоотой сургалтын чанарт анхаарч ажиллаж байна.
- ХАБЭА-н хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг жил бүр хийдэг. Энэ баталгаажуулалтад сонирхогч талуудын оролцоог хангаж ажиллаж байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Анхаарах асуудал:**

- Хяналт шинжилгээ үнэлгээний газар нь байгууллагын бүтэц дээр харьяалал буруу байгааг анхаарах
- Чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааг зохицуулж байгаа 7 журмын сайжруулалтыг анхаарах

#### **Зөвлөмж:**

- Чанарын дотоод аудитыг зөв аргачлалаар хийх талаар судлах, багш нарыг сургах, чанарын дотоод аудитуудыг бэлдэх, дотоод аудитыг тогтмолжуулах, хэвшүүлэх тал дээр анхаарах

#### **7.2. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

#### **Илрэл нотолгоо:**

- Төгсөгчдөөс сэтгэл ханамжийн судалгааг жил бүр авдаг.
- Төгсөгчдийн ажил эрхлэлт, ажлын байрны нийцлийн судалгааг төгссөнөөс хойш 2 жил тутам хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.
- ХАБЭА-н ангиар төгсөгчдийн төгсөлтийн чанар 100 хувь байна.
- Төгсөгч оюутныг ажлын байраар хангаж буй ажил олгогчдоос сэтгэл ханамжийн судалгаа авдаг. Судалгааны үр дүнд үндэслэн арга хэмжээнүүдийг авч байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Эрүүл ахуй суурьтай ХАБЭА мэргэжилтэнг бэлтгэж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Эрүүл ахуй тал руугаа илүү анхаарч байснаас ХАБ тал дээр дутагдалтай тал ажиглагдаж байгааг анхаарах
- ХАБ тал дээр мэргэжлийн сургалтын төвүүдтэй хамтарч ажиллах боломжийг судлах

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн төгсөгчидтэй байнгын эргэх холбоотой байх тал дээр анхаарах

#### **7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.



**Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэлийн үнэлгээг 2017 онд хийлгэн Магадлан итгэмжлэгдсэн. ASIIN-ий туршилтын магадлан итгэмжлэлд амжилттай орсон.
- Азийн 100 топ сургуулийн нэг болох зорилт тавин ажиллаж байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан****Анхаарах асуудал:**

- Чанарын үнэлгээг багш нарын гүйцэтгэлтэй холбож өгөх

**Зөвлөмж:**

- ХАБЭА-н хөтөлбөрт жил бүр өөрийн үнэлгээ хийж үндэсний болон олон улсын жишигт хүрэхийн тулд судлагаа хийж нөөц бололцоог бий болгох тал дээр анхаарч ажиллах
- АШУУС-ийн НЭМС нь менежментийн тогтолцооны суурийг зөв тавьж, зөв удирдаж байгаа тул олон улсын Боловсролын байгууллагын Чанарын менежментийн тогтолцооны ISO 21001:2018 стандартыг хэрэгжүүлж баталгаажуулалт хийлгэхийг зөвлөж байна.

**V. ДҮГНЭЛТ**

АШУУИС-ийн НЭМС-ийн “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” хөтөлбөрт шинжээчийн багаас дараах нэгдсэн үнэлгээг өгч байна.

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1.	Хөтөлбөрийн төлөвлөлт	2	1	-	Бүрэн хангасан
2.	Сургалтын үйл ажиллагаа	2	1	-	Бүрэн хангасан
3.	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3	-	-	Бүрэн хангасан
4.	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5	-	-	Бүрэн хангасан
5.	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	4	1	-	Бүрэн хангасан
6.	Багшийн үйл ажиллагаа	4	-	-	Бүрэн хангасан
7.	Чанарын үнэлгээ, баталгаажилт	3	-	-	Бүрэн хангасан
Нийт		23	3	-	Бүрэн хангасан

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг АШУУИС-ийн НЭМС-ийн “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагын дагуу “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.



Шинжээчийн багийн дүгнэлтийг Үйлчилгээний чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг ...../Р.Чанцалдулам/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Б.Цогзолмаа/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Ц.Хишигжаргал/

## НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

Сургуулийн нэр	АШУҮИС-ийн НЭМС
Хөтөлбөрийн нэр	“Хөдөлмөрийн аюлгүй байдал, эрүүл ахуй”
Хөтөлбөрийн индекс	102201
<b>ЗӨВЛӨМЖ</b>	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ol style="list-style-type: none"> <li>1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний тандан судалгааг хийхдээ нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчин, улс төрийн болон хүмүүсийн эрэлт хэрэгцээ, орчин үеийн технологийн дэвшилтэд хөтөлбөр нь хэрхэн холбогдож байгааг судлах, судалгааны аргад STEEP, POEMS зэрэг аргыг ашиглах;</li> <li>2. Хөтөлбөрийн зорилго, зорилтод хүрэх стратеги төлөвлөлтийг хийж, түүнийг үнэлэх арга, хэмжих нэгжийг тодорхой болгон жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж ажиллах;</li> <li>3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгийг шинэчлэн сайжруулах;</li> <li>4. Өөрчлөгдөн буй хөдөлмөрийн зах зээлийн эрэлт шаардлагад нийцүүлэн хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, төгсөгчийн цогц чадамжийг дахин шинэчлэн боловсруулах.</li> </ol>
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ol style="list-style-type: none"> <li>1. Сургалтын хөтөлбөрийн сайжруулалтыг үндсэн баримт бичигт тусгаж тасралтгүй сайжруулалтыг хийж хэвших;</li> <li>2. Хөтөлбөрийн хувьд сурган заах арга, суралцахуйн үнэлгээ нь хоорондоо харилцан уялдаатай байх талд анхаарч хичээлийн түвшнээс хөтөлбөрийн түвшинд хүртэлх сургалтын болон үнэлгээний арга хэлбэрийн төлөвлөлт, хэрэгжүүлэлт, сайжруулалтыг тасралтгүй хийдэг тогтолцоог бүрдүүлэх;</li> <li>3. Хөтөлбөрийн хичээл нэг бүрийн суралцахуйн үр дүнг (CLOs) хичээлийн явцад болон төгсгөлд хэрхэн үнэлэх арга зүйн зөвлөмжийг боловсруулан суралцагчдад хүртээл болгох;</li> <li>4. Мэргэжлийн хөтөлбөрийн хувьд хичээлийн үнэлгээ, арга зүйг сайжруулах чиглэлээр зөвхөн мэргэжлийн тэнхимийн багш төдий биш бусад тэнхимээс тухайн хөтөлбөрт ордог багшийн хичээл, түүний үнэлгээ, арга зүйд анхаарч хөтөлбөр төвтэй ажиллах.</li> </ol>
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ol style="list-style-type: none"> <li>1. Сургуульд оюутны бие даан суралцах орчныг илүү нэмэгдүүлж, оюутны хөгжлийн төв”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулж, байнгын үйл ажиллагаатай болгох;</li> <li>2. Профессор багш нар гадаадын их дээд сургуулиудад ашигладаг сонгодог сурах бичгийг Монгол хэл рүү орчуулж сургалтад ашиглах талд анхаарах;</li> <li>3. Салбарын хөгжлөөс байнга суралцаж шинэлэг мэдээллүүд, сургалтын хэрэглэгдэхүүн, сургалт судалгааны программ хангамжийг ашиглах, хөгжүүлэх боломжуудыг эрэлхийлэх;</li> <li>4. ХЭМАБ-ын хөтөлбөр нь Монгол улсын хэмжээнд шинэ байгаа тул ном сурах бичгийн тал дээр сайжруулах шаардлага гарсаар байгаа, иймээс сургалтын</li> </ol>

	хөтөлбөр, агуулгатай уялдуулж ном сурах бичгийн сан бий болгох тал дээр анхаарах;
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ol style="list-style-type: none"> <li>1. Хөтөлбөрийг сайжруулах, удирдах чиглэлд хөтөлбөрийн оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлж хамтын ажиллагааг бэхжүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлэх;</li> <li>2. Хөтөлбөрийг сайжруулах талаар хөтөлбөрийн хороод төлөвлөгөө гаргаж ажиллах</li> <li>3. Мэргэжлийн төгсөгчдийн холбоог байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах.</li> <li>4. Нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, нийгэмд байгаа бодит асуудлуудыг шийдэхэд багш, оюутнуудыг татан оролцуулах талд анхаарах.</li> <li>5. Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөх үйлчилгээг хийх;</li> <li>6. Хөтөлбөрийн маркетингийн бодлогыг хэрэгжүүлэхдээ мэдээллийн технологийн хөгжлийн ололтыг ашиглах бодлого баримтлах.</li> <li>7. Маркетингийн идэвхжүүлэлтийн арга хэмжээний ажлын төлөвлөгөө, тайлан, түүнээс гарсан үр дүнг нэгтгэн цаашдын үйл ажиллагаандаа тусгаж байх</li> <li>8. Мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж элсэлтийг нэмэгдүүлэх</li> </ol>
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ol style="list-style-type: none"> <li>1. Ажил олгогчийн болон нийгмийн эрэлт хэрэгцээний захиалгад үндэслэн элсэлтээ бүрдүүлэх талаар элсэлтийн бодлогыг чиглүүлж ажиллах;</li> <li>2. Цаашид оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн дагуу ХАБЭА-н оюутнуудын сайн дурын хөдөлмөр эрхлэлт, бүтээлч байдлыг дэмжсэн бодлого хэрэгжүүлэх;</li> <li>3. Элсэлтийг нэмэгдүүлэхэд оюутан суралцагчдын оролцоог нэмэгдүүлэх, элсэлт бүрдүүлэхэд оролцсон оюутнуудыг урамшуулах гэх мэт шилжилт, хөдөлгөөнтэй холбоотой асуудлыг жил бүр авч хэрэгжүүлж байх</li> <li>4. Төгсөлтийн дараах мөшгих судалгааг хийж байх</li> </ol>
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ol style="list-style-type: none"> <li>1. Багш нарыг албан тушаалын зэрэглэл ахихад анхаарч ажиллах, ялангуяа дадлагажигч багш нарын зэргийг ахиулахад анхаарах;</li> <li>2. Багшийн заах арга, ур чадвар, хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүйг хөгжүүлэхэд багшийн хөгжлийг чиглүүлэх</li> <li>3. Төсөлт ажилд багш нарыг жигд оролцуулах, төсөл хөтөлбөрөөс орох санхүүжилтээс багш нарыг чадвахуулах, урамшуулах боломжийг бий болгох</li> <li>4. Багшийн үнэлгээний нэгдсэн дүнгээс хөтөлбөрийн хэмжээнд сайжруулах болон түгээн дэлгэрүүлэх сайн арга зүй, сургалт, судалгааны ажлыг нэгтгэн хөтөлбөртөө тусган шинэчлэл хийж байх.</li> </ol>
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ol style="list-style-type: none"> <li>1. Чанарын дотоод аудитыг зөв аргачлалаар хийх талаар судлах, багш нарыг сургах, чанарын дотоод аудиторыг бэлдэх, дотоод аудитыг тогтмолжуулах, хэвшүүлэх тал дээр анхаарах</li> <li>2. ХАБЭА-ын хөтөлбөрт жил бүр өөрийн үнэлгээ хийж үндэсний болон олон улсын жишигт хүрэхийн тулд судлагаа хийж нөөц бололцоог бий болгох тал дээр анхаарч ажиллах</li> <li>3. Хөтөлбөрийн төгсөгчидтэй байнгын эргэх холбоотой байх тал дээр анхаарах</li> </ol>
<b>ШААРДЛАГА</b>	
1.2.	Хөтөлбөрийн зорилго(PEOs), хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд(PLOs) хичээлийн хүрэх үр дүн (CLOs)-г боловсруулахдаа хамт олноор хэлэлцүүлдэг, хэлэлцүүлгийн үр дүнд гарсан шийдвэрийг тусгадаг тухай нотлох баримтыг бүрдүүлдэг байх;
2.1.	Сургалтын хөтөлбөрийн агуулгад сайжруулалтыг хийх
5.1.	Элсэлтийг нэмэгдүүлэхэд маркетингийн идэвхжүүлэлт, хөтөлбөрийн ил тод байдлыг нэмэгдүүлж хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангах

#### IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

##### I. Багш нарын нэрс

№	Овог нэрс	Албан тушаал	Заадаг хичээл	Утас	Сонгосон байдал
1	Д.Гантуяа	АУ-ны доктор дэд проф, ЭБТ эрхлэгч	Тархвар судлал	99189915	gantuya.d@mnums.edu.mn
2	Б.Ариунсанаа	АУ-ны доктор, профессор	Ерөнхий бичил амь судлал	94028828	Ariunsanaa.b@mnums.edu.mn
3	М.Нансалмаа	НЭМ-ийн магистр	Хөдөлмөрийн эрүүл ахуй	99908958	Nansalmaa.m@mnums.edu.mn
4	Ө.Батцэцэг	ХУ-ны доктор	Анагаахын хими	99004069	battsetseg@mnums.edu
5	Б.Батчимэг	ТУ-ны магистр	ХАБ	88090812	batchimeg.ba@mnums.edu.mn
6	Н.Туул	БУ-ны магистр	Хүнсний эрүүл ахуй	99088193	tuul.n@mnums.edu.mn
7	Г.Жаргалсайхан	НЭМ-ийн магистр	Хор судлал	88009879	Jargalsaikhan.g@mnums.edu.mn
8	Х.Сэр-Од	МУ-ны магистр	Биостатистик	88054755	serod@mnums.edu.mn
9	Ч.Аззаяа	АУ-ны магистр	Сэтгэл судлал	88096447	azzaya.ch@mnums.edu.mn
10	Ж.Маргад-Эрдэн	АУ-ны магистр	Эрүүл мэндийг дэмжих		Margad-erdene@mnums.edu.mn
11	Ө.Гандолгор	АУ-ны магистр	УСАУ	86004026	gandolgor@mnums.edu.mn
12	Ц.Төгс	ХШ-ийн магистр	Англи хэл	99290631	tugs@mnums.edu.mn

##### II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Утас	емайл
1	Б.Энхжин	I	Хэнтий аймгаас суралцаж байгаа		<a href="mailto:hss22i009@st.mnums.edu.mn">hss22i009@st.mnums.edu.mn</a>
2	Ц.Цэрэнпил	I			<a href="mailto:HSS22D005@st.mnums.edu.mn">HSS22D005@st.mnums.edu.mn</a>
3	З.Дөлгөөн-Эрдэнэ	I			<a href="mailto:hss22d006@st.mnums.edu.mn">hss22d006@st.mnums.edu.mn</a>
4	С.Анх-Эрдэнэ	I	Дээд лигт тоглодог		<a href="mailto:hss22i010@st.mnums.edu.mn">hss22i010@st.mnums.edu.mn</a>
5	П.Алтанзул	I	Хэсгийн ахлагч	80441702	<a href="mailto:hss22d001@st.mnums.edu.mn">hss22d001@st.mnums.edu.mn</a>
6	Л.Жаргалмаа	II		89734998	<a href="mailto:hss21d004@st.mnums.edu.mn">hss21d004@st.mnums.edu.mn</a>
7	С.Яруун	II		94873373	<a href="mailto:hss21d005@st.mnums.edu.mn">hss21d005@st.mnums.edu.mn</a>

8	Б.Мягмарсүрэн	II	Эрдэнэтээс суралцаж байгаа	95792390	<a href="mailto:hss21d006@st.mnums.edu.mn">hss21d006@st.mnums.edu.mn</a>
9	Б.ОюунЭрдэм	II	Хэсгийн ахлагч	88690909	<a href="mailto:hss21d009@st.mnums.edu.mn">hss21d009@st.mnums.edu.mn</a>
10	Б.Батхүлэг	III	Хэсгийн ахлагч	99697118	<a href="mailto:Hs20d001@st.mnums.edu.mn">Hs20d001@st.mnums.edu.mn</a>
11	Б.Бүжинлхам	III			<a href="mailto:Hs20d003@st.mnums.edu.mn">Hs20d003@st.mnums.edu.mn</a>
12	Д.Мөнхбаяр	III			<a href="mailto:Hs20d004@st.mnums.edu.mn">Hs20d004@st.mnums.edu.mn</a>
13	М.Урангоо	IV		89247717	hs19d003@st.mnums.edu.mn
14	Ц.Хулан	IV	Хэсгийн ахлагч	99523442	hs19d004@st.mnums.edu.mn
15	А.Лхагвацэнд	IV		95606033	hs19d005@st.mnums.edu.mn

### III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	албан тушаал	Утас	емайл
1	Алгирмаа	УГТЭ	Захиргаа хүний нөөц хэлтэсийн дарга	88046600	aligirmaab@gmail.com
2	Х.Тулгаа	Монголын хүний нөөцийн удирдлага шинэчлэлийн академи	Сургалтын албаны дарга	86112333	hr.tulгаа@gmail.com
3	Эгиймаа	"Таван Толгой Түлш" ХХК	ХАБ хяналтын инженер	99064548	Egiimaas1117@gmail.com
4	Лхагвадорж	Digital Concept LLC	Захирал	91005937	Lkhagvadorj.b@digitalconcept.mn
5	Н.Цэцэнбилэг	ЮНИТЕЛ ХХК		89110844	tsetsenbileg.n@unitel.mn
6	С.Золзаяа	ONDO ХХК		66116699	zolzaya.s@ondo.mn
7	С.Дуламсүрэн	Өвөрхангай МХГ дарга	МХГ дарга	99006308	duka_1919@yahoo.com
8	Х.Чинзаяа	МСН үнэлгээний төв	Чанарын менежер	80070107	chinzaya.oh@gmail.com
9	Бат-Оргил	ГССҮТ	Захирлын ажлын албаны дарга	99149330	batorgil.vv@gmail.com
10	Батаа	MMSE Цахилгаан ХХК	ХАБ цехийн хэлтсийн дарга	99606900	bataa@mmse.mn

### IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага, албан тушаал	Утас	емайл
1	Н.Алтансүх	2021	Дорноговь ЭМГ Орчны ЭМ мэргэжилтэн	85876556	n.altansukh1720@gmail.com
2	Б.Золзаяа	2021	УГТЭ ХАБЭА-мэргэжилтэн	90550613	zoloob837@gmail.com

3	Ч. Энхчимэг	2021	Монголын хүний нөөцийн удирдлага шинэчлэлийн академи ХАБЭА ахлах багш	99953422	enkhlife9@gmail.com
4	Б.Сайнбилэг	2021	"Таван Толгой Түлш" ХХК ХЭА	94442336	tttsainaa@gmail.com
5	Б. Хулан	2021	Digital Concept LLC ХАБЭА менежер	94250309	hulan03090609@gmail.com
6	Б. Энх-Амар	2021	Өгөөж-Чихэр Боов ХХК ХАБЭА менежер	80920999	amraamraa165@gmail.com
7	О. Хонгорзул	2022	Таван толгой түлш ХХК ХЭА	80189599	hongorzul003@gmail.com
8	Б.Заяасайхан	2022	ЮНИТЕЛ ХХК ХАБЭА Инженер	86119136	zayasaikhan.b@unitel.mn
9	Б. Гантулга	2022	ONDO ХХК ХАБЭА мэргэжилтэн	85136645	gantulga.b@ondo.mn
10	М. Одхүү	2022	Өвөрхангай аймгийн МХГ ХЭА улсын байцаагч	80249492	odkomb01@gmail.com
11	А. Мядагмаа	2022	Хурд групп ХАБ	88813156	hs18d006@st.mnums.edu.mn
12	Б. Номин	2022	Сэлэнгэ МХГ ХЭА	99494143	snomin1107@gmail.com
13	Х. Пэлжидмаа	2022	МСН үнэлгээний төв ХЭА	80383110	hs18d015@st.mnums.edu.mn
14	М.Балжинням	2022	Таван богд ХХК ХАБ	80336411	baljkabaljka0000@gmail.com
15	Ц.Отгонзаяа	2022	MMSE ХХК	95892332	otgonzaya@mmse.mn

## V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/



**АШУУИС**

**АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ  
ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ  
НИЙГМИЙН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН СУРГУУЛЬ**

С.Зоригийн гудамж, Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар хот, ш/х-48/111, 14210  
Утас: +976-11-32 91 26

Цахим шуудан: [publichealth@mnums.edu.mn](mailto:publichealth@mnums.edu.mn)

2022. 12. 08 № 1/214

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хариу илгээх тухай

**БОЛОВСРОЛЫН  
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ-Д**

АШУУИС-ийн НЭМС-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (D102201) бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-өөр Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэхээр гэрээг 2022 оны 5-р сард байгуулсан. Магадлан итгэмжлүүлэх ажил гэрээнд заасан төлөвлөгөөний дагуу явагдаж, шинжээчид 2022 оны 11 сарын 21,22-ны өдрүүдэд АШУУИС дээр ажиллаж нотлох баримттай танилцсан.

Шинжээчдийн өгсөн зөвлөмжийг 2022 оны 12 сарын 6-ны өдөр хүлээж авсан ба бид шинжээчдийн өгсөн зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байгааг тус албан тоотой илэрхийлж байна.

Хамтран ажилласан та бүхэнд баярлалаа

ЗАХИРАЛ



Д.ДАВААЛХАМ